



Ерөнхийлөгч Томас С.Монсон

# Үлгэр жишээ мөн Гэрэл байгтун

*Бид Аврагчийн үлгэр жишээг дагах үед,  
бусдын амьдралд гэрэл болох боломж бидэнд ирэх болно.*

**А**х, эгч нар аа, та нартайгаа дахин хамт байх сайхан байна. Та нарын мэдэж байгаачлан, бид өнгөрсөн 4-р сард уулзсанаас хойш ерөнхийлөгч Боид К.Пакэр, ахлагч А.Том Пэрри, ахлагч Ричард Г.Скотт нарын гурван хайртай төлөөлөгчөө алдсандаа гашуудаж байна. Тэд тэнгэрлэг гэртээ буцсан. Бид тэднийг үгүйлж байна. Бид тэдний Христийнхтэй адил хайрын жишээнд болон бид бүгдэд үлдээсэн сүнслэгээр өдөөгдсөн сургаалуудад гүнээ талархдаг.

Бид шинээр дуудагдсан төлөөлөгчид болох ахлагч Роналд А.Расбанд, ахлагч Гари И.Стивэнсон, ахлагч Дэйл Г.Рэнланд нарт тавтай морилно уу гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Энэ эрчүүд бол Их Эзний үйлсэд өөрсдийгөө зориулсан хүмүүс билээ. Тэд дуудагдсан чухал албан тушаалдаа бүрэн тэнцэх хүмүүс юм.

Сүүлийн үед намайг судар уншиж, тунгаан бодох явцад хоёр шүлэг санаанаас минь гарахгүй байна. Бид тэдгээрийг хоёуланг мэддэг.

Эхнийх нь “Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг”<sup>1</sup> хэмээх Уулан дээрх номлоос авсан шүлэг юм. Хоёр дахь нь намайг эхний судрыг уншаад, тунгаан бодож байхад санаанд минь орж ирсэн. Энэ нь төлөөлөгч Паулын Тимотод бичсэн захидлын хэсэг бөгөөд “Чи итгэгч хүмүүст үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариун байдлаараа үлгэр дуурайл бол”<sup>2</sup> гэсэн шүлэг юм.

Хоёр дахь судрын шүлэг нь эхний шүлгийг хэрхэн хэрэгжүүлэхийг тод томруун тайлбарладаг гэж би боддог. Бид хэл, яриа, энэрэл, сүнс, итгэл ба цэвэр ариун байдалдаа Есүс Христийн сургаалыг дагаж амьдарснаар итгэгчдийн жишээ болж чаддаг. Биднийг тийнхүү үйлдэхэд, бидний гэрэл бусдад харагдахуйц гэрэлтэх болно.

Бидний хүн нэг бүрийг дэлхий дээр ирэхэд Христийн гэрэл өгөгдсөн. Бид Аврагчийн үлгэр жишээг дагаж, Түүний хэрхэн амьдарч,

заасанчлан амьдрах юм бол тэрхүү гэрэл бидний дотор асаж, бусдын явах ёстой замыг гэрэлтүүлэх болно.

Төлөөлөгч Паул гэрлийг маань гэрэлтүүлэх, итгэгчийн зургаан зан чанарыг жагсаасан. Эдгээрийг нэг нэгээр нь авч үзье.

Би эхний хоёр зан чанарыг хамтатгаад, үг хэл ба яриагаараа үлгэр жишээ үзүүлэх талаар дурдъя. Бидний хэрэглэдэг үгс бусдыг дэмжин, сүнслэгээр нөлөөлж, эсвэл гэмтээн шархлуулж, гутааж чадна. Өнөө үед дэлхий дээр эргэн тойронд маань хараал, бүдүүлэг үг хэллэг дэндүү их байх шиг санагддаг. Бурханы нэрийг хайнга, бодлогогүй хэрэглэж байгааг сонсохоос зайлсхийхэд ч хэцүү болжээ. Бүдүүлэг үгс зурагт, кино, ном, дуу хөгжимд түгээмэл байдаг энгийн зүйл болсон байна. Доромжилсон, бухимдсан үгс солилцдог болж. Бүгдээрээ бусадтай хайр хүндэтгэлтэй харьцаж, өөрсдийн хэл яриаг цэврээр нь хадгалан, бусдыг гомдоож, шархлуулах үг хэлэхээс зайлсхийцгээе. Бид тохинуулынхаа туршид найрсаг, хүлээцтэй ярьдаг байсан Аврагчийнхаа жишээг дагах болтугай.

Паулын дурдсан дараагийн зан чанар нь “Христийн цэвэр хайр”<sup>3</sup> хэмээн тодорхойлогддог тэрхүү энэрэл юм. Бидний танилын хүрээн дотор ганцаардсан, өвдсөн, зориг нь мохсон хүмүүс байгаа гэдэгт би итгэлтэй байна. Тэдэнд тусалж, тэдний сүнсийг өргөх боломж бидэнд бий. Аврагч итгэл найдвараа алдсан хүнд найдварыг мөн сул дорой хүнд хүч чадлыг авчирдаг байсан. Тэр өвчтөнүүдийг эдгээж;

хазгарыг алхдаг, сохрыг хардаг, дүлийг сонсдог болгосон. Тэрээр үхсэнийг хүртэл амиуулсан. Тэр тохинууллынхаа туршид гачигдагсдад энэрэлтэй ханддаг байсан. Бид Түүний үлгэр жишээг даган дуурайвал бусдын болон өөрсдийн амьдралыг адислах болно.

Дараа нь бид зан хандлагаараа үлгэр жишээ байх ёстой. Миний хувьд энэ нь амьдралдаа найрсаг зан, талархал, уучлал, сайн сайхан зан чанарыг байлгана гэсэн үг. Эдгээр зан чанар нь биднийг өөрсдийн эргэн тойрны хүмүүсийн амьдралд нөлөөлөх сүнсээр хангах болно. Би он жилүүдийн туршид тийм сүнс бүхий үй олон хүнтэй уулзах боломжтой байсан. Бид тэдэнтэй хамт байхдаа онцгой зүйлийг мэдэрдэг ба уг мэдрэмж нь тухайн хүмүүстэй харилцаа холбоотой байж, тэдний жишээг дагах хүслийг бидэнд төрүүлдэг. Тэр хүмүүс Христийн гэрлийг цацруулж, Түүний бидний төлөө хайрыг мэдрэхэд бидэнд тусалдаг.

Цэвэр ариун, хайраар дүүрэн хүнээс ирдэг гэрлийг бусад хүн хэрхэн мэдэрдгийг харуулахын тулд би олон жилийн өмнө болсон нэг явдлыг та нартай хуваалцъя.

Тэр үед Сүмийн удирдагчид Сүмийн Иерусалим төвийг барих газар түрээслэх гэрээ байгуулахаар Иерусалимын албан тушаалтнуудтай уулзсан юм. Шаардлагатай зөвшөөрлүүдийг олж авахын тулд уг төвд байрлах Сүмийн гишүүд маань шашныхаа талаар гудамжинд бусадтай хуваалцахгүй гэдгийг Сүм зөвшөөрөх ёстой байв. Гэрээ байгуулсны дараа Сүмийг болон Сүмийн гишүүдийг сайн мэддэг Израилийн нэгэн албан тушаалтан, Сүм гудамжинд шашны талаар хуваалцахгүй гэсэн энэ гэрээндээ үнэнч байна гэдгийг би мэдэж байна хэмээн дурдаж билээ. Тэнд сургуульд явах оюутнуудын талаар тэр “Гэвч тэдний нүдэнд гэрэлтэх тэрхүү гэрлийн тухайд бид ямар нэгэн зүйл хийх хэрэгтэй юм биш үү?”<sup>4</sup> гэж хэлсэн юм. Тэрхүү гэрэл

үргэлж биднээс гэрэлтэж, бусдад танигдаж, бусдын талархлыг хүртдэг байгаасай.

Итгэлийн үлгэр жишээ байна гэдэг нь бид Их Эзэнд болон Түүний үгсэд итгэдэг гэсэн үг юм. Энэ нь бодол санаа, үйл хөдлөлийг маань удирддаг тийм итгэлийг бид эзэмшиж мөн хадгалдаг гэсэн үг юм. Бидний Их Эзэн Есүс Христэд болон Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэл маань бидний хийдэг бүх зүйлд нөлөөлөх болно. Бидний үе дэх эргэлзээ, ухамсрын зөрчилдөөн, өдөр тутмын амьдралын үймээн самуун дунд байнгын итгэл маань бидний амьдралын зангуу болдог. Итгэл, эргэлзээ хоёр нэг оюунд зэрэг оршиж чадахгүй, учир нь нэг нь нөгөөгөө хөөдөг гэдгийг санаарай. Бидэнд ахин дахин сануулсаар байдаг нэгэн зүйлийг би давтан хэлье. Бид өөрсдөдөө хэрэгтэй итгэлийг олж, хадгалахын тулд судруудыг уншиж, судалж, тунгаан бодох нь нэн чухал юм шүү. Залбирлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэйгээ холбоотой байх нь зайлшгүй чухал. Дайсан болон түүний туслагчид бидний итгэлтэй байдал буурахыг, хуяг дуулганд маань зай завсар гарахыг зогсолтгүй эрэлхийлж байдаг учраас бид эдгээр зүйлийг ойшоохгүй байж болохгүй. Их Эзэн “Хичээнгүйлэн судлагчид, үргэлж залбирагчид, мөн итгэлтэй байгчид, мөн та нарын сайн сайхны тулд бүх зүйл хамтдаа ажиллах болно”<sup>5</sup> хэмээн хэлсэн.

Эцэст нь, бид цэвэр ариун байх ёстой. Энэ нь бид бие махбод, оюун ухаан, сүнсэндээ цэвэр байна гэсэн үг юм. Бидний бие бол бишрэл, хүндэтгэлтэй хандвал зохих ариун сүм гэдгийг бид мэднэ. Бидний оюун санаа урмаар тэтгэгдэн, өөдрөг бодол санаагаар дүүргэгдэж, бохирдуулагч зүйлсээс ангид байх ёстой. Бид Ариун Сүмийг өөрсдийн байнгын хамтрагч байлгахын тулд зохистой байх ёстой. Ах, эгч нар аа, цэвэр ариун байдал нь бидэнд оюун санааны амар амгаланг авчирч, Аврагчийн

амалтуудыг хүлээн авахад биднийг тэнцүүлнэ. Тэрээр “Зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд Бурханыг харах болно”<sup>6</sup> хэмээжээ.

Бид үг хэл, хэл яриа, хайр энэрэл, зан байдал, итгэл, цэвэр ариун байдлаар үлгэр жишээ гэдгээ нотолсноор, дэлхийд гэрэл нь болоход тэнцэх болно.

Биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн бидэнд өгсөн зарчим, удирдамжуудаас дэлхий улам бүр холдох тусам бид бусдаас өөр учраас олны дундаас ялгагдах болно гэдгийг би та нарт бүгдэд, ялангуяа залуу үеийнхэндээ хэлмээр байна. Бид даруу хувцасладаг учраас бусдаас ялгарах болно. Бид хараал хэлдэггүй мөн биед маань хортой бодисүүдийг хэрэглэдэггүй учраас бусдаас өөр байх болно. Бид зохисгүй шог яриа, бусдыг доромжлох зэргээс зайлсхийдэг учраас бусдаас өөр байх болно. Бид гэр орон, амьдралаас маань сүмсийг холдуулдаг, ёс суртахуунгүй нэвтрүүлэг, дуу хөгжмөөр оюун санаагаа дүүргэхгүй гэсэн шийдвэр гаргаснаараа бусдаас өөр байх юм. Бид ёс суртахууны сонголтыг буюу сайн мэдээний зарчим, жишгүүдэд нийцэх сонголтыг хийснээрээ бусдаас онцгойрон ялгарах болно. Дэлхийн олонхоос биднийг ялгаруулдаг энэ зүйлүүд нь улам түнэр харанхуй болж буй дэлхийг гэрэлтүүлэх гэрэл хийгээд сүнсээр биднийг хангадаг юм.

Өөр байж, олны дунд ганцаар зогсох нь ихэнхдээ хэцүү байдаг. Бусад хүн юу гэж бодох бол эсвэл хэлэх бол гэж санаа зовох нь эгэл хүний шинж чанар юм. Дуулал дахь: “Эзэн бол миний гэрэл болон миний аврал юм. Хэнээс би эмээх юм бэ? Эзэн бол миний амийн хамгаалалт юм. Хэнээс би айх юм бэ?”<sup>7</sup> хэмээх үгс биднийг тайтгаруулдаг. Бид Христийг амьдралынхаа төв болгох үед айдас зовнил маань бидний итгэл үнэмшлийн зоригоор солигдох болно.

Бидний хэний маань ч амьдрал төгс биш, заримдаа бидэнд

тулгарах зовлон бэрхшээл дааж давшгүй мэт санагдаж гэрлийг маань бүдгэрүүлж болно. Гэхдээ бид Тэнгэрлэг Эцэгийн тусламж ба бусдын дэмжлэгтэйгээр замыг маань дахин гэрэлтүүлж, бусдад хэрэгтэй байж болох гэрлийг өгөх тэрхүү гэрлийг эргүүлэн олж авч чадна.

Үүнийг харуулахын тулд би олон жилийн өмнө анх удаа уншиж байсан дуртай шүлгийнхээ сэтгэл хөдлөм үгсийг та нартай хуваалцъя:

*Би шөнийн харанхуйд  
Дэнлүү нь унтарсан, үл таних  
нэгэнтэй дайралдав.  
Би түр саатан,  
Өөрийнхөө дэнлүүгээр түүний-  
хийг асаав.*

*Хожим нь хуй салхи босч,  
Газар дэлхийг доргиов,  
Харин салхи намжихад,  
Дэнлүү минь унтарчихсан  
байв.*

*Тэгтэл нөгөө үл таних нэгэн  
буцаж ирэхэд*

*Түүний дэнлүү бадран асааж  
байв.  
Тэрээр үнэ цэнэт дөлөө надад  
ойртуулж,  
Миний дэнлүүг асааж өгөв!<sup>8</sup>*

Ах, эгч нар аа, бид өөрсдөө ямар ч нөхцөлд байсан, бусдыг гэрэлтүүлэх боломж биднийг хүрээлэн байдаг. Бид Аврагчийн үлгэр жишээг дагах үед гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хамт ажилладаг хүмүүстээ, мөн зүс таних төдий юм уу танихгүй хүмүүст ч амьдралд нь гэрэл болох боломж бидэнд ирэх болно.

Та нарын хүн нэг бүр Тэнгэрлэг Эцэгийн хөвгүүн мөн охин гэдгийг би хэлье. Та нар энэ дэлхий дээр түр хугацаагаар амьдрахын тулд мөн Аврагчийн хайр, удирдамжийн жишээ болж, бүгдэд харуулахын тулд гэрлээ зоригтой гэрэлтүүлэхээр Түүний дэргэдээс холдон ирсэн билээ. Дэлхий дээрх түр зуурын хугацаа дуусах үед та нар хийх ёстой зүйлээ хийсэн л бол, Түүнтэй мөнхөд хамт амьдрахаар буцаж очих алдар суут адислал та нарынх байх болно.

Аврагчийн: “Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно”<sup>9</sup> хэмээх үгс сэтгэлийг ихэд тайвшруулдаг. Би Түүнийг гэрчилж байна. Тэр бидний Аврагч, Гэтэлгэгч, Эцэгийн өмнө өмгөөлөх Өмгөөлөгч билээ. Тэр бидэнд Жишээ үзүүлэгч мөн бидний хүч чадал юм. Тэр бол “харанхуйд гялалзагч гэрэл”<sup>10</sup> юм. Миний дуу хоолойг сонсох хүн бүр Түүнийг дагахаар амлаж, тэгснээр дэлхийг гийгүүлэгч гэрэл нь болоосой хэмээн би Их Эзэн Есүс Христийн ариун нэрээр залбирч байна, амен.

#### ЭШЛЭЛҮҮД

1. Матай 5:16
2. 1 Тимот 4:12
3. Моронай 7:47
4. Жэймс И. Фауст, “The Light in Their Eyes,” *Лиакхона*, 2005 оны 11-р сар, 20
5. Сургаал ба Гэрээ 90:24
6. Матай 5:8
7. Дуулал 27:1
8. Lon Woodrum, “Lamps,” *The Lighted Pathway*, 1940 оны 10-р сар, 17.
9. Иохан 8:12
10. Сургаал ба Гэрээ 6:21

## Бидэнд зориулсан сургаал

2015 оны 11-р сараас эхлэн 2016 оны 4-р сар хүртэл Мелкизедек сан-ваартнууд ба Халамжийн нийгэмлэгийн дөрөв дэх ням гаргийн хичээлийг 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн нэг ба түүнээс дээш үгийг сонгон бэлтгэж заана. 2016 оны 4-р сард 2015 оны 10-р сарын эсвэл 2016 оны 4-р сарын чуулган дээр хэлсэн үгсийн алийг нь ч сонгож болно. Гадас, дүүргийн ерөнхийлөгчид Ерөнхий чуулган дээр хэлсэн үгийг сонгож эсвэл энэ үүргийг бишоп, салбарын ерөнхийлөгчдөд даалгаж болно.

Эдгээр хэлсэн үгийг [conference.lds.org](http://conference.lds.org) хаягаар олон хэлээр унших боломжтой.



Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

# Таны хамтрагч болох Ариун Сүнс

*Хэрэв бид зохистой амьдрах аваас,  
Сүнсний адислалыг зөвхөн хааяа нэг биш, харин үргэлж авч чадна.*

**Х**айрт ах, эгч нар аа, Би Их Эзний Ерөнхий чуулган болж буй энэ хүндэтгэлийн өдөр та нартай хамт байгаадаа талархаж байна. Би хэлсэн үгс ба дуулуудыг сонсож суухдаа, тэдгээр нь үнэн гэж Сүнс, Ариун Сүнс гэрчлэхийг та нарын адил мэдэрсэн.

Миний өнөөдрийн зорилго бол биднийг баптисм хүртсэний дараа хүн нэг бүрд амлагдсан тэрхүү бэлгийг авах хүсэл, эрс шийдэмгий байдлаа нэмэгдүүлэх явдал юм. Бид гишүүний баталгаагаа хүлээн авч байхдаа “Ариун Сүнсийг хүлээн авна уу”<sup>1</sup> гэх үгсийг сонсдог. Тэр мөчөөс эхлэн бидний амьдрал мөнхөд өөрчлөгдсөн.

Хэрэв бид зохистой амьдрах аваас, Сүнсстэй байх адислалыг зөвхөн өнөөдрийнх шиг ийм гайхалтай үйл явдлуудаар хааяа нэг биш, харин үргэлж авч чадна. Та нар энэхүү амлалт хэрхэн биелэгддэгийг ариун ёслолын залбирлын “Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, үүнээс хүртэх тэд бүгдийн бодгалийн тул;

тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд таны Хүүгийн биеийг төлөөлөн дурсаж, тэд үүнийг идэж, Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, тэд өөрсөдөө таны Хүүгийн нэрийг авч, мөн үргэлж түүнийг санаж, мөн өөрсөд нь өгсөн түүний зарлигуудыг дагахад бэлэн гэдгээ танд гэрчилж болохын тулд, энэ талхыг адисалж мөн ариулахыг таны Хүү, Есүс Христийн нэрээр бид танаас гуйж байна” хэмээх үгсээс мэдэж авдаг.

Дараа нь: “Тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө *үргэлж* хамт байлгаж болохын тулд” гэсэн гайхамшигтай амлалт өгдөг (С ба Г 20:77; тодотгол нэмэгдсэн).

Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгах гэдэг нь өдөр тутмын амьдралдаа Ариун Сүнсний удирдамж, зааврыг авч байна гэсэн үг юм. Жишээ нь, Сүнс бидэнд хилэнцийг үйлдүүлэх уруу таталтыг эсэргүүцэхийг сэрэмжлүүлж болно.

Тиймээс, Их Эзний үйлчлэгчид ариун ёслолын цуглаанд Бурханыг

шүтэн бишрэх бидний хүслийг өсгөн нэмэгдүүлэхийг хичээдэг шалтгааныг харахад хялбар байдаг. Хэрэв бид ариун ёслолоос итгэлтэй хүртвэл, Ариун Сүнс биднийг болон бидний хайртай хүмүүсийг улам хүчтэй, нэмэгдэн ирж буй уруу таталтаас хамгаалах болно.

Ариун Сүнсний нөхөрлөл нь сайн сайхан зүйлсийг илүү сэтгэл татам болгон, уруу таталтын хүчийг сулруулдаг. Зөвхөн энэ нь бидэнд Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгахад зохистой байх шийдвэр гаргахад хангалттай үндэслэл болох юм.

Ариун Сүнс биднийг нүгэл хилэнцийн эсрэг хүчирхэгжүүлдгийн адил, бидэнд үнэн, худалыг ялгах хүчийг мөн өгдөг. Хамгийн чухал үнэнийг зөвхөн Бурханаас ирэх илчлэлтээр бататгах боломжтой. Үүнд хүмүүн бидний ямар ч тайлбар эсвэл биеийн мэдрэхүйг ашиглах нь хангалтгүй. Бид хамгийн мэргэн ухаантай нь ч гэсэн ухаалгаар далдлан нууцалсан худаал хуурмагаас үнэнийг ялгахад бэрх болсон цаг үед амьдарч байна.

Их Эзэн, Аврагчийн сорвинд хүрч, Түүний амилаалт бодит гэдгийг нотлохыг хүссэн Өөрийн төлөөлөгч Томаст: “Есүс түүнд, чи намайг харсан учраас итгэв үү? Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй еэ!” (Иохан 20:29) хэмээн айлдан, илчлэлт бол илүү найдвартай нотолгоо гэдгийг заасан байдаг.

Бурхан руу, гэртээ буцаж очих замыг тэмдэглэдэг үнэнүүдийг Ариун Сүнс баталж өгдөг. Бид ойн цоорхой руу очин; Эцэг, Хүү хоёр залуу Иосеф Смиттэй ярьж байгааг харах боломжгүй. Түүнчлэн, амласны дагуу Елиа ирэн, өнөө үед

амьд бошиглогч Томас С.Монсон эрхийг нь атган, хэрэглэж байгаа санваарын түлхүүрүүдийг өгсөн болохыг батлах ямар ч бодит нотолгоо, логик тайлбар байхгүй.

Ариун Сүнснийг хүлээн авах эрхтэй Бурханы охинд эсвэл хүүд үнэний баталгаа ирдэг. Бид ямар ч үед худал юм уу хуурмаг зүйлтэй тулгарч болох учраас эргэлзээ төрүүлэхгүйн тулд Үнэний Сүнсний нөлөөг үргэлж өөрсөдтэйгөө хамт байлгах хэрэгтэй юм.

Жорж К.Каннон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байхдаа Сүнснийг өөрсөдтэйгөө хамт байлгахыг үргэлж эрэлхийлж байхыг биднээс хүссэн. Тэрээр, хэрэв бид энэ зөвлөгөөг дагах аваас, үнэний талаарх “мэдлэгээр хэзээ ч дуагдахгүй”, “харанхуйд эсвээс эргэлзэлд хэзээ ч орохгүй”, мөн бидний “итгэл хүчтэй, [бидний] баяр хөөр . . . дүүрэн”<sup>2</sup> байх болно гэж амласан бөгөөд би ч ийнхүү амлаж байна.

Бидэнд Ариун Сүнсний нөхөрлөлийн тусламж байнга хэрэг болдог өөр нэг шалтгаан бий. Хайртай хэн нэгэн маань санаандгүй нас барж болно. Хайртай нэгнээ алдах үед биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн ба амилсан Аврагчийн бодит байдлын талаар ирэх Ариун Сүнсний гэрч бидэнд найдвар, тайвшрал өгдөг юм. Үхэл тохиолдох үед энэ талаарх шинэ соргог гэрчлэл бидэнд байх ёстой.

Тиймээс, олон шалтгаанаар бидэнд Ариун Сүнсний байнгын нөхөрлөл хэрэгтэй. Бид энэ нөхөрлөлийг хүсдэг ч, үүнийг хадгалан үлдэх нь хэцүү гэдгийг өөрсдийн туршлагаас мэднэ. Бидний хүн нэг бүр өдөр бүр Сүнснийг гомдоох зүйлсийг бодож, хэлж мөн хийдэг. Их Эзэн, бидний зүрх сэтгэл энэрлээр дүүрч, бодол санааг ариун журам зогсолтгүй чимэн гоёсон үед Ариун Сүнс бидний байнгын хамтрагч байх болно гэж заасан (С ба Г 121:45-ыг үзнэ үү).

Сүнсний нөхөрлөлийн бэлгийг авах шаардлагыг хангах өндөр

жишигт хүрч чадахгүй байгаа хүмүүст би энэ урмын үгийг уламжилъя. Та нарт Ариун Сүнсний нөлөөг мэдэрч байсан үе бий. Магадгүй өнөөдөр ч та нар мэдэрсэн байж болно.

Та нар ийм сүнсээр удирдагдсан мөчүүдэдээ Алмагийн дүрслэн хэлсэн итгэлийн үртэй адил ханд (Алма 32:28-ыг үзнэ үү). Тэдгээрийг нэг бүрчлэн тарь. Та нар мэдэрсэн сүнслэг өдөөлтийнхөө дагуу үйлдсэнээр үүнийг хийж чадна. Хамгийн үнэ цэнэтэй Сүнслэг өдөөлт бол та бүхний хувьд Бурхан та нараар юу хийлгэх байсан бол гэдгийг мэдэх явдал юм. Хэрэв танд аравны нэгээ төл эсвэл гашуудаж буй найз дээрээ оч гэсэн мэдрэмж төрсөн бол та үүнийг хийх хэрэгтэй. Ямар ч мэдрэмж төрсөн байсан, түүнийгээ даган хий. Та нар дуулгавартай байхад бэлэн байгаагаар харуулах юм бол Ариун Сүнс та нарт Түүний хийлгэхийг хүссэн зүйлсийн талаар илүү олон сүнслэг өдөөлтийг илгээх болно.

Та нар дагах аваас Сүнснээс ирэх өдөөлт улам бүр ойр ойрхон ирж, байнгын нөхөрлөлд илүү ойртохоос гадна зөвийг сонгох хүч тань нэмэгдэх болно.

Түүний төлөө үйлд гэсэн эдгээр сүнслэг өдөөлт нь таны хүсэл биш, харин Сүнснээс ирсэн гэдгийг та нар мэдэх боломжтой. Та нарын хүлээн авсан сүнслэг өдөөлт Аврагчийн болон Түүний амьд бошиглогч, төлөөлөгчдийн хэлсэн үгтэй таарч байвал, итгэлтэй дагах сонголтыг хийж болно. Тэр үед Их Эзэн Өөрийн Сүнснийг та нартай хамт байлгах аар илгээнэ.

Жишээлбэл, хэрэв та нар хүндэтгэлийн өдрийг сахих сүнслэг өдөөлтийг хүлээн авах юм бол, ялангуяа дагахад хэцүү гэж санагдсан тэр үед чинь Бурхан Өөрийн Сүнснийг туслуулахаар илгээх юм.

Олон жилийн өмнө аавыг маань ажлаар Австралид очиход түүнд яг ийм тусламж ирсэн билээ. Тэр ням гарагт ганцаархнаа байсан бөгөөд ариун ёслолоос хүртэхийг хүсжээ. Түүнд хожмын үеийн

гэгээнтнүүдийн цуглаануудын талаар ямар ч мэдээлэл олдохгүй байлаа. Тиймээс тэр гараад алхаж эхэлсэн байна. Замын уулзвар дээр ирэх болгондоо тэр хаашаа эргэж явах талаар залбирч байжээ. Тэр бүтэн цагийн турш алхан, нааш цааш эргэж явсаар, дахин залбирахаар зогсжээ. Тэрээр нэг тодорхой гудамж руу эргэ гэж хэлэх сүнслэг өдөөлтийг мэдэрсэн байна. Удалгүй ойрхон нэгэн орон сууцны байрны доод давхраас дуу дуулах чимээ сонсогджээ. Тэр цонхоор нь харахад цагаан бүтээлэг бүтээн, дээр нь ариун ёслолын тавиур тавьсан ширээний ойролцоо суусан цөөн хэдэн хүнийг харсан байна.

Энэ нь та нарт тийм ч чухал гэж санагдахгүй байж болох ч, түүний хувьд гайхалтай зүйл байсан. Аав маань, “гэд түүний Сүнснийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд мөн үргэлж түүнийг санаж, мөн өөрсдөд нь өгсөн түүний зарлигуудыг дагахад бэлэн” (С баГ 20: 77) хэмээх ариун ёслолын залбирлын амлалт биелэгдсэнийг мэдсэн юм.

Энэ бол түүний залбираад, дараа нь Бурханы хийгээсэй гэж хүссэн зүйлийг Сүнсний хэлснээр хийсэн жишээнүүдийнх нь нэг юм. Тэр он жилүүдийн туршид ийнхүү үйлддэг байсан ба би ч, та нар ч мөн адил ийнхүү хийх болно. Тэр хэзээ ч өөрийн сүнслэг байдлын тухай ярьж байгаагүй. Тэр зүгээр л хийх хэрэгтэй хэмээн сүнслэг өдөөлт авсан жижиг зүйлсийг Их Эзэний төлөө үргэлжлүүлэн хийсээр байв.

Хожмын үеийн гэгээнтнүүдийн зарим бүлэг хүн өөрсдөд нь хандан үг хэлэхийг түүнээс хүсэх болгонд тэр үг хэлдэг байсан. Түүнд арван хүн байна уу, тавин хүн байна уу, эсвэл тэр өөрөө хэр их ядарсан байх нь хамаагүй байв. Тэрээр Сүнс түүнийг өдөөн гэрчил гэх болгонд Эцэг, Хүү, Ариун Сүнснийг болон бошиглогчдын талаарх гэрчлэлээ хуваалцдаг байлаа.

Түүний Сүм дэх хамгийн том дуудлага бол Ютагийн Боннэвилл

гадасны дээд зөвлөлд байсан ба уг дуудлагат ажлаа хийж байхдаа тэр гадасны ферм дээр зэрлэг өвс зулгааж, Ням гаргийн ангид хичээл заадаг байв. Олон жилийн туршид түүнд хэрэгтэй үед нь Ариун Сүнс хамтрагч нь болдог байсан юм.

Би эмнэлгийн өрөөнд аавынхаа хажууд зогсож байлаа. Түүнтэй 41 жил ханилсан ээж минь орон дээр хэвтэж байв. Бид түүний биеийн байдлыг олон цагийн турш ажиглан суусан. Ээжийн маань нүүрнээс өвчин шаналал нь арилан одохыг бид харж байлаа. Алгандаа зангидсан хуруунууд нь тавигдан, гар нь хажуу тал руугаа гулсан унав.

Хорт хавдраар өвдсөн хэдэн арван жилийн зовлон шаналал нь ийнхүү төгсгөл болж байлаа. Би ээжийнхээ царайнаас амар амгалан олж харсан юм. Ээж минь хэдхэн богино амьсгал аван, амьсгаа нь тасалдсанаа, чимээгүй болж билээ. Бид хоёр ахиад амьсгал авах болов уу хэмээн горьдон, хүлээж зогссон.

Эцэст нь, аав минь аяархнаар, “Бяцхан охин минь гэр рүүгээ явлаа даа” гэж хэлсэн юм.

Тэр ямар ч нулимс дуслуулсангүй. Учир нь олон жилийн өмнө түүнд Ариун Сүнс ээжийг минь хэн болохыг, мөн түүний хаанаас ирснийг болон түүнийг хэн болсныг, бас хаашаа явж байгаа талаар тод томруун дүр зургийг үзүүлсэн байсан юм. Сүнс аавд минь олон удаа, бидэнд хайртай Тэнгэрлэг Эцэгийн ба үхлийн хүчийг дийлсэн Аврагчийн талаар, мөн аавын маань эхнэртэйгээ болон гэр бүлтэйгээ хуваалцсан ариун сүмийн лацдан холболт нь бодит болохыг гэрчилсэн байв.

Олон жилийн өмнө Сүнс аавд минь ээжийн сайхан сэтгэл, итгэл нь түүнийг тэнгэр дэх гэртээ буцаж очих эрхтэй болгосон гэдгийг, мөн тэнд түүнийг амлалтын гайхамшигтай хүүхдийн хувьд нэр хүндтэй хүлээн авна гэсэн баталгааг өгсөн байв.

Аавын минь хувьд энэ нь найдвараас илүү зүйл байсан юм. Ариун

Сүнс түүнд энэ бүхнийг бодит зүйл болгон өгсөн байлаа.

Зарим хүн тэнгэрлэг гэр орны талаарх түүний үгс, оюун ухаанд нь байх дүр зургууд зүгээр нэг сэтгэлийн хөөрөл, хайртай нэгнээ алдсан нөхөр хүний харалган ухаан гэж хэлж болох юм. Гэвч аав минь мөнхийн үнэнийг олж мэдэх боломжтой цорын ганц арга замаар түүнийг мэдэж авсан байв.

Тэр нас биед хүрсэн бүхэл амьдралынхаа туршид бодит дэлхийн тухай үнэнийг эрэлхийлсэн эрдэмтэн хүн байсан. Тэр шинжлэх ухааны арга хэрэгслүүдийг сайн ашиглаж чаддаг байсан бөгөөд дэлхий даяарх мэргэжил нэгтнүүдийнхээ хүндлэлийг хүлээсэн нэгэн байсан юм. Тэр химийн шинжлэх ухааны салбарт хийсэн ихэнх судалгаага, эхлээд молекулуудыг энд тэндгүй хөдөлж байгааг оюун ухааныхаа мэлмийгээр хараад, дараа нь өөрийн үзэгдлийг лабораторид туршиж, баталдаг байв.

Гэвч тэрээр өөрт нь болон бидний хүн нэг бүрд хамгийн чухал үнэнүүдийг олж мэдэхийн тулд өөр арга замыг баримталж байсан. Бид зөвхөн Ариун Сүнсээр дамжуулан хүмүүсийг төдийгүй үйл явдлыг Бурханы мэлмийгээр харж чаддаг билээ.

Энэ бэлэг нь түүнд эхнэрийг нь нас барсны дараа эмнэлэгт үргэлжлэхийг би харсан юм. Бид ээжийнхээ эд юмсыг цуглуулан, авч явахар янзлав. Машин руу явах замд аав минь тааралдсан бүх эмч, сувилагчтай саатан уулзаж, талархлаа илэрхийлж билээ. Тэр үед би дотроо цухалдангуй, бид гашуудаж болохын тулд ганцаар байх ёстой гэж бодож байснаа санаж байна.

Гэхдээ одоо би, аав минь зөвхөн Ариун Сүнс л үзүүлж чадах зүйлсийг олж харсан юм байна гэдгийг ойлгосон билээ. Тэрээр эмнэлгийн ажилтнуудыг хайртай хүнийг нь харж халамжлахаар Бурханаас илгээгдсэн тэнгэр элч гэж харж байлаа. Тэд өөрсдийгөө эмнэлгийн мэргэжилтнүүд гэж үзэж байсан

ч, аав маань Аврагчийн өмнөөс хийсэн тэдний үйлчлэлд талархлаа илэрхийлж байв.

Бид аав, ээж хоёрынхоо гэрт ирэхэд ч Ариун Сүнсний нөлөө түүнтэй хамт байсан. Бид зочдын өрөөнд хэдэн минут ярилцсаны дараа аав маань уучлалт гуйгаад, ойр байх унтлагынхаа өрөө рүү оров.

Хэдэн минутын дараа тэрээр зочны өрөөнд сайхан гэгч инээмсэглэсээр буцан орж ирж билээ. Тэр бидэн рүү дөхөж ирээд, аяархнаар “Би Милдрэдийг сүнсний дэлхийд ганцаараа очих вий гэж санаа зовж байлаа. Би түүнийг олны дунд төөрөх байх даа гэж бодож байв” гэж хэлсэн юм.

Тэгээд аав ихэд баяртай “Би дөнгөж сая залбираад, Милдрэд дажгүй байгааг олж мэдлээ. Ээж маань түүнийг угтахаар тэнд очсон байна” хэмээн хэлж билээ.

Би түүнийг ингэж хэлэхэд нь, бэрийгээ ирэхэд тэврэн угтахаар богино хөлөөрөө яаравчлан, хурдан хурдан алхалж байгаа эмээгээ төсөөлөн бодож, инээмсэглэснээ санаж байна.

Аав маань хүүхэд байхаасаа л үргэлж итгэлтэй залбирдаг байсан учраас хүссэн тайвшралаа хүлээн авч чадсан юм. Тэр зүрх сэтгэлд нь тайвшрал, удирдамж өгөхөөр ирдэг хариултыг хүлээн авч сурсан байлаа. Тэр залбирах дадал хэвшлээс гадна, судрыг болон амьд бошиглогчдын үгсийг мэддэг байв. Тиймээс тэр та нарын өнөөдөр мэдэрсэн байж болох Сүнсний танил шивнээг таньдаг байсан юм.

Сүнсний нөхөрлөл түүнийг тайтгаруулж, удирдаад зогсохгүй Есүс Христийн цагаатгалаар дамжуулан түүнийг өөрчилсөн юм. Биднийг Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгана гэсэн амлалтыг хүлээн авахад Аврагч бидэнд бүх бэлгээс хамгийн агуу нь болох мөнх амьдралд ороход шаардлагатай цэвэршилтийг өгөх болно (С ба Г 14:7-г үзнэ үү).

Та нар: “Эдүгээ уг зарлиг нь энэ болой: Ариун Сүнсний хүлээн

авалтаар та нар ариусагдаж болохын тулд, эцсийн өдөр та нар миний өмнө толбогүйгээр зогсож болохын тулд наманчлагтун, мөн надад ирэгтүн мөн миний нэрээр баптисм хүртэгтүн, газар дэлхийн хязгаарууд та нар бүгд” (3 Нифай 27: 20) гэсэн Аврагчийн үгсийг сана.

Тэдгээр зарлиг нь:

“Мөн эдүгээ, үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, сайныг үйлдэхэд--тийм ээ, шударгаар үйлдэхэд, даруухнаар алхахад, зөв шударгаар шүүхэд хөтөлдөг тэр Сүнсэнд итгэлээ тавигтун; мөн энэ нь миний Сүнс бөлгөө.

“Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, оюуныг чинь гэгээрүүлж, сүнсийг чинь баяраар дүүргэх Сүнснээсээ би чамтай хуваалцах болно”

(С ба Г 11:12– 13) гэсэн Их Эзний амлалттай хамт ирдэг.

Би Бурхан Эцэг амьд, амилсан Есүс Христ Өөрийн Сүмийг удирдаж, ерөнхийлөгч Томас С.Монсон санваарын бүх түлхүүрийг эзэмшдэг, мөн Ариун Сүнсээр дамжин ирэх илчлэлт нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг болон түүний даруухан гишүүдийг удирдан, дэмждэг талаарх өөрийн гэрчлэлийг та нартайгаа хуваалцаж байна.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийн хувьд Их Эзэн Есүс Христийн гэрч болж, бидэнд хандан үг хэлсэн эдгээр гайхалтай ах Бурханаас дуудагдсан гэдгийг би та нарт гэрчилж байна. Сүнс

ерөнхийлөгч Монсонг тэднийг дуудахад удирдсан гэдгийг би мэднэ. Та нар тэднийг болон тэдний гэрчлэлүүдийг сонсох үед Ариун Сүнс миний одоо та нарт хэлж буй зүйлсийг баталсан. Тэд Бурханаар дуудагдсан. Би тэднийг дэмждэг бөгөөд тэдэнд хайртай. Их Эзэн тэдэнд хайртай бөгөөд үйлчлэлд нь тэднийг дэмжинэ гэдгийг би мэднэ. Би үүнийг Их Эзэн Есүс Христийн нэрээр хэллээ, амен.

#### ЭШЛЭЛҮҮД

1. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 20.3.10.
2. Жорж К.Каннон, “Minutes of a Conference,” *Millennial Star*, 1832 оны 5-р сарын 2, 275–276-г үзнэ үү.